



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.03.15 № 06/152
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хэнтий-Ус ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ch. Erdenebaatar* Ч.ЭРДЭНЭБААТАР

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ХЭНТИЙ-УС ХХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг:

Аудитор: Н.Туяа
Утас: 70562147
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн үндэслэн санхүүгийн тайланд /ХЭА-2018/7/СТА-ОНӨААН/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн захирал нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд аудитыг 2018 оны 03 дугаар сарын 05 -наас 2018 оны 03 дугаар сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Н.Туяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 03 дугаар сарын 05 -наас 2018 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Компанийн захирал нь Монгол улсын Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хэнтий-Ус ХХК-ий үйл ажиллагааны үндсэн зорилт нь "нийтийн аж ахуйн үйлчилгээг хүн бүрт чанартай хүртээмжтэй хүргэн ажиллахад оршино", Хэнтий-Ус ХХК-ий үйл

ажиллагааны үндсэн чиглэл нь "Ус хангамж, ариутгал татуурга, дулаан хангамж, нийтийн хууль ус, барилга засвар үйлчилгээ түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх явдал мөн" гэж компаний дүрэмд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төрийгээ санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ" гэж заасан байна. Мөн хуулийн 1, дугаар зүйлийн 18.1-д " Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана", мөн Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна." гэж заасны дагуу Хэнтий-Ус ХХК-ийн гүйцэтгэх захирал үүргийг гүйцэтгэж байна.

Хэнтий- Ус компанийн дүрмийн 7.6-д "захирал нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна. 7.6.1 " Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, компанийн дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэж заасан байна.

Хэнтий-Ус ХХК-ний гүйцэтгэх захирлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилдог. Хэнтий-Ус ХХК-ний гүйцэтгэх захиралтай ажил гүйцэтгэх гэрээг Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон Төлөөлөн Удирдах зөвлөл байгуулж хяналт тавьж ажилладаг. Хэнтий-Ус ХХК-ний 2017 оны бизнес төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөл баталж түүний дагуу зарцуулж байна.

Компанийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 8-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт

125

Бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Компанийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Ординат ХХКийн "Unicus" санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед их гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Хэнтий-Ус ХХК нь ХААН банк, ХАС банк, Төрийн банк, Капитал банкин дахь харилцах дансдаар болон байгууллагын мөнгөн кассаар дамжуулан орлого, зарлагын гүйлгээг хийж гүйцэтгэлийг хангах, зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2017 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг авч үзвэл 3,376.4 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, улсын төсвөөс 300.0 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 3676,4 сая төгрөгийн орлого орж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 3,176.9 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 274.4 сая төгрөгөөр илэрхийлэгдэж, нийт 3,615.4 сая төгрөгийн зардал гарч 61.0 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

- Компаний нийт 10,541.6 сая төгрөгийн хөрөнгийг авч үзвэл 4.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 374.9 сая төгрөгийн дансны авлага, 217.3 сая төгрөгийн бараа материал, 9,945.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө байна.
- Богино хугацаат өр төлбөр 510.7 сая төгрөг, урт хугацаат өр төлбөр 2,040.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, хуримтлагдсан алдагдал 400.0 сая төгрөгөөр илэрхийлэгджээ.
- Санхүүгийн тайлан дахь урт хугацаат өр төлбөрийн 2,040.2 сая төгрөгийн үлдэгдэл нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2004 оноос 9 аймагт Нийтийн ахуй үйлчилгээний ажлыг сайжруулах дэмжих зорилгоор олгогдсон төслийн зээлийн өглөг байна.
- 2017 оны борлуулалтын орлогын төлөвлөгөөг 95.3 хувиар биелүүлж ажиллажээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг шалгахад батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, төсөл арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний ерөнхий мэдээлэл, өмчийг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлэг, өмч, хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх тушаал шийдвэр, гэрээ хэлцэл, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, аливаа хяналт шалгалтын тайлан зэрэг 86 мэдээллийг бүрэн мэдээлээгүй, 55 мэдээллийг хугацаа хоцроосон байна. 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс 2,374.9 сая төгрөгийн 101 орлогын гүйлгээ, 547.4 сая төгрөгийн 27 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 3.1 “ Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1. төрийн болон орон нутгийн өмчит этгээд ”, 5.1 Төрийн болон орон нутгийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газар дараах агуулга бүхий мэдээллийг дор дурдсан хэлбэрээр тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ. 7.1 “ Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ: 7.1.1. “.... төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”, 7.1.3 “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 8 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байх, тооллого тооцоог хийхгүй байх, өглөг, авлагыг бүртгэлд үнэн зөв тусгахгүй байх зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Компанийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. ЛАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Хэрэгжүүлсэн горим сорилоор шилжүүлэх болон актлах шийдвэр гарсан 200.4 сая төгрөгийн 7 тээврийн хэрэгслийг данснаас хасаагүй, өмнөх онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5.1 "Орон нутгийн өмчит хуудийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн хөрөнгө акталж данснаас хасах тухай асуудлаа улирал хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан баланс гаргахаас өмнө Орон нутгийн өмчийн албанд ирүүлж зохих шийдвэр гарсаны дараа хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

2. Бараа материалын үлдэгдлийг данс, дансаар тулган шалгахад дэлгэрэнгүй бүртгэлд түүхий эд материалын 1401- 010000-012 дансанд бөөн дүнгээр 155.2 сая төгрөгийн 1 ширхэг бараа материал гэсэн үлдэгдэлтэй, ямар нэр төрлийн материал гэдэг нь баримтаар нотлогдохгүй, биетээр байхгүй байна. Дээрхи ямар нэр төрлийн, хаана байгаа нь тодорхойгүй бараа материалыг тооллогын комисс үлдэгдэлтэй байгаагаар бүртгэл гарган хянан баталгаажуулж, тооллогыг чанаргүй хийж, үр дүн, үлдэгдлийг үнэн зөв батлгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна. 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" , Компанийн дүрмийн 8.4 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг ерөнхий нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ." гэсэн заалтуудыг хангалтгүй хэрэгжүүлж, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

3. Хэрэгжүүлсэн горим сорилоор татварын өр төлбөрийг татварын байгууллагатай тулган баталгаажуулахад НӨАТ-ын өглөг 26.1 сая төгрөгөөр дутуу, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.2 сая төгрөгөөр дутуу, усны төлбөр 14.1 сая төгрөгөөр дутуу, цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгах татвар 25.7 сая төгрөгөөр илүү, татварын өглөг нийт 16.7 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.12.2." Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" 20.2.5 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

178

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад илэрсэн материаллаг бус алдаа зөрчлийг танилцуулвал:

1. Аудитын явцад 8,264.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй нь санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах боломжгүй болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна. 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

2. Хэрэгжүүлсэн горим сорилоор санхүүгийн тайланд тусгагдсан дансны өглөгийн 225.9 сая төгрөгийн 83 үлдэгдлийг тооцоо нийлсэн акттай тулгахад 42.2 хувь буюу 95.4 сая төгрөгийн 11 өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, 130.5 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.12.2." Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" 20.2.5 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дараагийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,434.5 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 355.6 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 3,078.9 сая төгрөгийн 4 зөрчлийг дахин давтахгүй байх 4 зөвлөмж хүргүүлэв.


Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Хэнтий-Ус ХХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд "Ай Жэй Эй Эйч-Аудит" ХХК аудитыг хийж, хязгаарлалттай санал дүгнэлт өгч, аудитаар 6 зөвлөмж өгөгдсөн нь 50 хувь хэрэгжсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий-Ус ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд 4 хуудсыг тус тус хавсаргав.



Хянасан:

Тэргүүлэх аудитор

/ Ч.Эрдэнэбаатар/

Аудитын менежер

/ Д.Оюунтуяа/

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

/ Н.Туяа/

Огноо: 2018.03.15

Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар

180

**ХЭНТИЙ-УС ХХК-ИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Үндсэн хөрөнгийн талаар3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Өглөг, авлагын талаар4

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 1
Шилэн дансны талаар5

2018 оны 03 дугаар сар

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг компаний удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий-Ус ХХК-ийн захирал Г.Батгэрэл, ерөнхий нягтлан бодогч Д.Эрдэнэбат болон нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

1. 8264805.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй нь санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах боломжгүй болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна. 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Хөрөнгийн тооллого тооцоог хийхгүй байх, хөрөнгө биетээр байхгүй байх, холбогдох хууль журам, стандартыг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хуульд заасан хугацаанд үнэн зөв, чанартай зохион байгуулж, тооллогын үр дүнг бүртгэл тайланд тусгаж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

АГ-ын ажиглалт

1. Хэрэгжүүлсэн горим сорилоор санхүүгийн тайланд тусгагдсан дансны өглөгийн 225914.7 мянган төгрөгийн 83 үлдэгдлийг тооцоо нийлсэн акттай тулгахад 42.2 хувь буюу 95407.9 мянган төгрөгийн 11 өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, 130506.8 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
2. Татварын өр төлбөрийг татварын байгууллагатай тулган баталгаажуулахад НӨАТ-ын өглөг 26118.7 мянгөн төгрөгөөр дутуу, үл хөдлөх хөрөнгийн татвар 2160.7 мянган төгрөгөөр дутуу, усны төлбөр 14058.1 мянган төгрөгөөр дутуу, цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгах татвар 25676.9 мянган төгрөгөөр илүү, татварын өглөг нийт 16660.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Эрсдэлүүд

Өр, авлагыг үнэн зөв илэрхийлэхгүй байх, холбогдох хууль журам, стандартыг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. Санхүүгийн тайлан гаргахын өмнө өглөг, авлагын үлдэгдлийг бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулж байх.
2. Татварын өр авлагыг нягтлан бодох бүртгэл, тайланд үнэн зөв илэрхийлж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

АГ-ын ажиглалт

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгахад батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, төсөл арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний ерөнхий мэдээлэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлэг, өмч, хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх тушаал шийдвэр, гэрээ хэлцэл, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, аливаа хяналт шалгалтын тайлан зэрэг 86 мэдээллийг бүрэн мэдээлээгүй, 55 мэдээллийг хугацаа хоцроосон байна. 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс 2374874.6 мянган төгрөгийн 101 орлогын гүйлгээ, 547404.3 мянган төгрөгийн 27 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

АГ-ын зөвлөмж

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлвэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль журам, стандартыг мөрдөхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

ХЯНАСАН:

БЭЛТГЭСЭН:

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

23171442
СНОА0046 9074072

Огноо: 2018.03.15

Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Н.ТУЯА